



## НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

### Даргын дэргэдэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Дүрэм батлах тухай” А/164 дүгээр захирамжийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг, газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.6, 1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг, газрын өмнө тавигдсан зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар зөвлөх эрх бүхий газрын даргын дэргэдэх Зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Гишүүд:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга

Агаарын чанар, хяналт, зохион  
байгуулалтын хэлтсийн дарга

Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан  
ахлах мэргэжилтэн

Түлшний бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Дотоод ажил, шуурхай асуудал хариуцсан  
ажилтан

2. Газрын даргын дэргэдэх зөвлөл нь байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг, газрын өмнө тавигдсан зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхдээ баталсан журмын дагуу хуралдаж, нууцын баталгаа гарган ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2022 оны А/20 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц. ГАНБОЛД



Аhta/tushaal 2022/

1150500048